



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/29

Эрдэнэт

┌ Ажилтан сонгон шалгаруулах комисс,
журам батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 6.1.5, Монгол улсын Засгийн газрын “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 2017 оны 448 дугаар тогтоолын 2.5, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/346 тоот тушаалын “Хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хангах” хэсэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.1, 7.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ажилтан сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар, сонгон шалгаруулалтын дүнгийн нэгдсэн хуудас, дүнгийн хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллана.

3. Комиссын ажилд хяналт тавих, гарсан зөрчилд тухай бүр хариуцлага тооцох, тушаалын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр нь авч ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтанд үүрэг болгосугай.

4. Сонгон шалгаруулах журам батлагдсантай холбоотойгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын 2019 оны А/69 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  Ц.НАРАН-ЭРДЭНЭ



612300286

My doc:/tushaal/A4

БОЭТ-ийн захирлын 2023 оны ᠒᠒ сарын ᠒᠗
өдрийн ᠒᠒᠗ тушаалын нэгдүгээр хавсралт



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН

№	Ажлын хэсгийн бүрэлдхүүн	Албан тушаал	Бусад
1	Ажлын хэсгийн дарга	ЭЗЭЗ	Шаардлагатай тохиолдолд ЭМТҮЧАБА-ын болон бусад албадын дарга нарыг оролцуулах
1	Нарийн бичгийн дарга	ХНА-ын дарга	
3	Гишүүд	1. Сувилахуйн албаны дарга 2. Тасаг нэгжийн эрхлэгч 3. Сургалтын албаны дарга	



Сул гарсан ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам

НЭГ. Нийтлэг үндэслэл.

- 1.1 Орхон аймгийн Бүсийн Оношилгооны Эмчилгээний Төвд /цаашид эмнэлэг гэх/ сул гарсан ажлын байранд ажлын байранд тавигдах шаардлага хангасан ажилд орохыг хүссэн их эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн болон иргэдийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах зорилтын хүрээнд сул ажлын байранд ажилтан авахдаа энэхүү журмыг мөрдөх ба Монгол улсын “Төрийн албаны тухай хууль”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.
- 1.3 Энэхүү журмын зорилго нь байгууллагын зорилт, чиг үүргийн хүрээнд ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, мэргэшсэн чадварлаг ур чадвар сайтай, зөв ёс зүй, харьцаа хандлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор хуулийн дагуу ил тод, шударга үнэлж, сонгон шалгаруулах зарчмаар хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангахад оршино.

ХОЁР. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт.

- 2.1 Захирлын тушаалаар томилогдсон сонгон шалгаруулах ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.
- 2.2 Тухайн сул гарсан ажлын байранд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журам, шалгаруулалтын явц, үр дүнг БОЭТ-ийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
- 2.3 Сонгон шалгаруулалтад оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлнэ. Нийтлэг шалгуурт тухайн шалгаруулалтад оролцогчийн ерөнхий мэдлэг, ур чадвар, ёс зүйн чадварыг үнэлнэ. Тусгай шалгуурт мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ажлын туршлага, гадаад хэлний мэдлэг зэргийг үнэлэн сонгон шалгаруулна.
- 2.4 Мэргэжлийн шалгалтын асуултыг мэргэжлийн багаар бэлдүүлж, нууцлалыг хамгаалж задруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хүний нөөцийн алба зохион байгуулна. Шалгалтын асуултыг задруулахыг хориглох бөгөөд задруулсан тохиолдолд задруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэж, дахин мэргэжлийн багт оруулж ажиллуулахгүй.
- 2.5 Шалгалтын асуултыг задруулсан гэж үзсэн тохиолдолд шинээр шалгалтын асуултыг дахин бэлдэж, авах ажлыг зохион байгуулна.
- 2.6 Ярилцлагын шалгалтад тухайн тасаг нэгжийн удирдах албан тушаалтныг оролцуулах бөгөөд мэргэжлийн шалгалтын дүнг танилцуулна.

ГУРАВ. Сонгон шалгаруулах комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.1 Ажилд горилогчийн материалыг хүлээн авах, хянан нэгтгэх
- 3.2 Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах
- 3.3 Сонгон шалгаруулалтын шалгалтын материал (тест) гарган батлах
- 3.4 Сонгон шалгаруулалтын дүнг хурлаараа хэлэлцэж дүнг гаргах
- 3.5 Сонгон шалгаруулалтын дүнг удирдлагын зөвлөлд танилцуулах

ДӨРӨВ. Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авч, бүртгэх.

- 4.1 Эмнэлгийн хүний нөөцийн алба нь сонгон шалгаруулалтад оролцогчоос материалыг хүлээн авч, огноо, цаг, минутыг тэмдэглэн оролцогчоор гарын үсэг зуруулж бүртгэлд бүртгэж авна.
- 4.2 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаанд материалыг хүлээн авах бөгөөд хугацаанаас хоцорсон тохиолдолд нөхөж бүртгэхгүй.
- 4.3 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах бүртгэлийн хугацаа дуусахад ажлын хэсэг ирсэн материалуудтай нэг бүрчлэн танилцаж, шаардлага хангасан материалуудыг бүртгэн авна.
- 4.4 Ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангаагүй, мэргэжлийн үнэмлэх, дипломгүй, баримт бичиг дутуу, хуулийн байгууллагад шалгагдаж байгаа иргэдийн материалыг хүлээн авахгүй.

ТАВ. Сонгон шалгаруулалт явуулах үе шат

5.1. Сонгон шалгаруулалтыг 3 үе шаттайгаар явуулна. Үүнд:

5.1.1. 1 дүгээр шат: Сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн материалтай танилцаж, тэдгээрийн бичиг баримтад үзлэг шалгалт хийх.

5.1.1. 2 дугаар шат: Ярилцлага хийх /Эхний шатанд сонгогдсон ажил горилогчтой ярилцлага хийнэ. Ярилцлагын явцад ажиллах иргэний гадаад байдал, зан байдал, хэл ярианы соёл, сонсох чадвар, өөртөө итгэлтэй байдал, сэтгэлзүй, сэтгэцийн байдал зэргийг үнэлнэ/

5.1.2. 3 дугаар шат: Мэргэжлийн шаардлагын магадалгаа.

- Тухайн ажлын байранд тавигдах шаардлагуудыг багтаасан ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох тест, ур чадварын шалгалт авах. /их эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нараас/
- Тасаг нэгжүүдэд тодорхой туршилтын хугацаагаар ажиллуулж мэргэжлийн чадварыг үнэлэх

5.2 Комисс нь сонгон шалгаруулалтыг энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан "Сонгон шалгаруулалтын дүнгийн нэгдсэн хуудас"-ны дагуу үнэлнэ.

- 5.3. Ажлын мэдлэг чадварыг 100 хүртэлх оноогоор дараах байдлаар дүгнэнэ
- 5.2.1. Бичиг баримтад үзлэг хийж танилцах 0-10 оноо
 - 5.2.2. Ярилцлага хийх өөрийгөө танилцуулах 0-30 оноо;
 - 5.2.3. Мэргэжлийн шаардлагын магадалгаа 0-60 оноогоор тус тус дүгнэнэ.
- 5.4 Нэр дэвшигч тус бүрээр оноог гаргаж хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг шалгаруулна.
- 5.5 Нийт оноо нь 60-аас доошгүй оноо авч байж тэнцсэн нэр дэвшигч 1 жилийн хугацаанд нөөцөд байна.
- 5.6 Мэргэжлийн шалгалтад тэнцсэн тохиолдолд эрүүл мэндийн үзлэгт хамруулна. /нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, бусад холбогдох шинжилгээ/
- 5.7 Эрүүл мэндийн үзлэгт ороогүй бол удирдлагын зөвлөлийн хуралт танилцуулахгүй бөгөөд нөөцөд хамруулахгүй.
- 5.8. Удирдлагын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн захирал ажилд томилох тушаал гаргана.

ЗУРГАА. Сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх.

- 6.1. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчдын тэнцсэн, тэнцээгүй тухай мэдээллийг өөрт нь холбогдох утсаар болон цахим хаягаар сонгон шалгаруулалтын шат бүрийн дараа хүргэнэ.
- 6.2. Ажлын хэсгийн дүнг комиссын дарга Удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногийн дотор танилцуулна.
- 6.3. Ажлын хэсэг захирлын гаргасан ажилд томилох тухай тушаалыг холбогдох иргэнд танилцуулж, чиглүүлэх сургалт зохион байгуулна. Тухайлбал: хүний нөөцийн ажилтан харьяалах тасаг, нэгжийн дарга, эрхлэгч, хамт олонд танилцуулсны дараа тасаг, нэгжийн дарга, эрхлэгч тасгийн үйл ажиллагаа, хамт олонд танилцуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу чиглүүлэх сургалтыг явуулна.

ДОЛОО. Бусад зүйл.

- 7.1. Сонгон шалгаруулалтын материал, дүнгийн нэгдсэн хуудсыг нэгтгэн цэгцэлж Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн архивт шилжүүлнэ.
- 7.2 Сонгон шалгаруулалтад дараагийн шаардлага хангасан ажил горилогчдыг хүний нөөцөд бүртгэн авна.
- 7.3 Сонгон шалгаруулалтаар сонгогдсон иргэн өөрийн хүсэлтээр тухайн ажилд томилогдохоос татгалзах тохиолдолд дараагийн шаардлага хангасан (хамгийн өндөр оноо авсан) ажил горилогчийг ажилд санал болгоно.
- 7.4 Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн мэргэжилтэнг байгууллагын санаачилгаар эргүүлэн авах тохиолдолд энэхүү журмыг мөрдөхгүй байж болно.
- 7.5. Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдол, маргаантай асуудлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, санал, гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

- 7.6. Ажлын хэсэг, ажлын хэсгийн гишүүд, оролцогчид нь сонгон шалгаруулалт явагдсанаас хойш 3 хоногийн дотор дараах үндэслэлээр сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах тухай гомдлыг Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн захиралд гаргах эрхтэй. Үүнд:
- 7.6.1. Шалгалтын тест задарсан бол
 - 7.6.2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг будилуулсан, устгасан бол
 - 7.6.3. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, нөлөөлсөн бол
- 7.7 Бүсийн Оношилгоо Эмчилгээний төвийн захирал дээрх гомдлыг шалгаад үндэслэлтэй гэж үзвэл сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож дахин сонгон шалгаруулалт явуулна. Хэрэв гомдол үндэслэлгүй бол энэ тухай гомдол гаргагчид 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 7.8 Комиссын гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах ба энэхүү журмыг зөрчсөн ажлын хэсгийн ажилтанд захиргааны арга хэмжээ тооцно.

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ

БОЭТ-ийн захирлын 2023 оны 02 сарын 28
өдрийн 4/4 тушаалын гуравдугаар хавсралт



Сонгон шалгаруулалтын дүнгийн нэгдсэн хуудас

Оролцогчийн сонирхож буй

Нэгжийн нэр.....

Мэргэжил

Албан тушаал

№	Шалгалтын төрөл	Авбал зохио оноо	Ажилтны нэр РД.....	Ажилтны нэр РД.....	Ажилтны нэр РД.....
1	Бичиг баримтын үзлэг	5			
2	Мэргэжлийн мэдлэг дадлага (онолын тест, дадлага)	5			
3	Ярилцлага	5			
	Нийт оноо	15			

Сонгон шалгаруулах комиссын

Дарга/ /
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Нарийн бичгийн дарга/ /
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

20 оны сарын өдөр

БОЭТ-ийн захирлын 2023 оны 42 сарын 18
өдрийн 4/29 тушаалын гуравдугаар хавсралт



Сонгон шалгаруулалтын дүнгийн хуудас

Оролцогчийн

.....(Ургийн овог)
.....(Эцэг эхийн нэр)
.....(Регистрийн дугаар)

Ажиллахыг сонирхож буй

Нэгжийн нэр.....
Мэргэжил.....
Албан тушаал.....

№	Шалгалтын төрөл	Шалгалт өгсөн оноо	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Бичиг баримтын үзлэг		5	5
2	Мэргэжлийн мэдлэг дадлага(онолын тест, дадлага)		5	5
3	Ярилцлага		5	5
	Нийт дүн		15	

Сонгон шалгаруулах комиссын

Дарга/ /
(Гарын үсэг) (Нэр)

Нарийн бичгийн дарга/ /
(Гарын үсэг) (Нэр)

Шалгаруулалтын дүнг зөвшөөрсөн

Иргэн
(Гарын үсэг) (Нэр)

20 оны сарын өдөр